

Баян-Олгий аймагт улаанбурхан овчний тохиолдол арван хоёр бүртгэгдэж нэг нь лабораторийн шинжилгээгээр батлагджээ. Бусад нь клиник шинж тэмдэг, анамнез асуумж судалгаагаар батлагдсан байна.

Аймгийн эрүүл мэндийн газрын "Улаанбурхан овчний тандалт судалгааг эрчимжүүлэх" тухай тушаал, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх тандалтын үйл ажиллагааны тоолоогоо гарч хот хоорондын автобус, Улаанбаатар, Олгий чиглэлийн онгоцонд байнгын тандалт судалгаа хийгдэж нийт мянга гаруй хүнийг хамааруулж, овчилсон ес оюутаны тавыг уг тандалт судалгааны явцад илрүүлсэн байна. Аймгийн хэмжээнд улаанбурханы овчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын хамралт 99,6%, үүнээс аймгийн төвд 99.9%, сумын түвшинд 99.7, багийн түвшинд 99.3 хувьтай байна гэж тус аймгийн мэргэжлийн хяналтын газар мэдээллээ.